

МОНГОЛ ОРНЫ ЖИЖИГ, ДУНД АЖ АХУЙ ЭРХЛЭХ НӨХЦӨЛ БА ОНЦЛОГ

*А.Даваасүрэн**

Энэхүү өгүүлэл нь Монгол Улсад аж ахуй эрхлэлтийн түүхэн хөгжилт, эдийн засгийн бүтцийг салбараар ба түүнд ажиллагчдын тоог хувийн жингээр гарган судлаж, ДНБ-д эзлэх жижиг дунд аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн хэмжээг тодорхойлох, мал аж ахуй болон бизнес эрхлэлтийн онцлог, эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалтыг салбараар нь гаргаж түүнд эзлэх жижиг дунд үйлдвэрийн нөхцөл болон тэдгээрийн үйл ажиллагааны онцлог шинж чанарыг тодорхойлон гаргаж, түүнийг алслагдсан хөдөө орон нутагт хөгжүүлэх талаар зарим саналыг дэвшүүлсэн болно.

Эрт дээр үеэс Монголын ард түмэн олон зууны туршид өөрийн өргөн уудам нутагт хүн, мал амьтан нь байгаль орчинтойгоо зохицсон бэлчээрийн мал аж ахуй эрхлэж, тэдгээрийн арьс шир, үс ноос болон бусад ашиг шим, түүхий эдээр хөрш зэргэлдээ улс орны ард түмэнтэй арилжаанд оролцож солилцох замаар өөрсдийн өдөр тутмын өргөн хэрэгцээгээ хангаж ирсэн байдаг. Харин нутгийн хойд хэсэгт амьдарч байсан ойн иргэд ангийн аж ахуй эрхэлж байснаас гадна газар тариалан эрхлэх гэж оролдож байсан түүх байдаг.

Иймд хүн ам маш сийрэг амьдардаг, тал нутаг зонхилсон өргөн уудам нутагтай, зах зээлийн багтаамж багатай Монгол шиг оронд мал аж ахуй эрхлэх нь уг ард түмний хувьд онцгой давуу тал болж, үүнийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх нөхцөл боломжтой юм гэж судлаачид дүгнэсээр ирсэн. Өөрөөр хэлбэл мал аж ахуй болон түүнтэй зохицсон жижиг аж ахуй нь тус орны эдийн засагт зонхилох байр суурь эзлэж ирсэн гэсэн үг.

1921 оны Ардын хувьсгалын дараа зарим малчин ард өөрсдийн ажилч хичээнгүй, хөдөлмөрч зан чанарын үр дүнд хувийн мал аж ахуйгаа өгсөн бойжуулсны үр дүнд мал нь өссөж малыг хөрөнгө гэж үзэх болж тэр үеэс иргэд өмч хөрөнгөтэй болох сонирхол тавигдсан гэж үзэж болно.

Гэвч тэр үеийн Ардын түр Засгийн зарим удирдлагын зүгээс шинэ тулгар засгийн газрыг бэхжүүлэх явцад нугалаа гарган том толгой ноёд феодалын өмч хөрөнгийг хураан авч нийгэмчлэх компани ажлыг хэд хэдэн удаа үе шаттай хэрэгжүүлснээр Монгол оронд ардын аж ахуйтан хөгжих бодит нөхцөл боломж устаж үгүй болоход хүрсэн.

Улмаар энэ нь 1950-аад оны сүүлчээр улс орон даяар “Нэгдэлжих Хөдөлгөөн” болон хувирч улам эрчимжиж малчин иргэд сайн дурын үндсэн дээр өөрт байгаа цөөхөн тооны малаа нэгдэлд хандивлаж нэгдлийн гишүүнээр элсэж байсан бол олон тооны малтай чинээлэг иргэд

* А.Даваасүрэн - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), профессор

нэгдэлжих хөдөлгөөнийг эсэргүүцэж малаа нэгдэлд өгөхөөс татгалзаж байсан. Гэвч тэр үед шинээр байгуулагдсан нэгдлийн дарга нарын зүгээс тэднийг хавчих гадуурхах, бэлчээр, ус ашиглуулахаас татгалзах зэрэг зохисгүй үйл ажиллагааны үр дүнд тэд өөрийн эрхгүй мал сүргээ нэгдэлд хандивлаж гишүүнээр элсэж байсан гашуун түүх байдаг. Ийнхүү эдгээр компанит ажлын үр дүнд ард иргэд хувийн өмчтэй байж жижиг аж ахуй эрхлэх бодит нөхцөл боломж бүрэн устаж үгүй болсон.

Энэ байдал нь социализмын үезд улам даамжирч хувийн өмч, хөрөнгөтэй, хувиараа аж ахуй эрхлэх сонирхолтой хүмүүсийг шуналтай, баян, дамын наймаачин гэж нүд үзүүлэн гадуурхах сэтгэхүй ард иргэдийн дунд улам хүчтэй бүрэлдэж 1990 оны Ардчилсан хувьсгалтай золгосон байдаг.

1990 оны эхэнд Монгол оронд өрнөсөн Ардчилсан хувьсгал ялж улс төрийн хувьд нэг намын тогтолцооноос олон намын тогтолцоо руу, эдийн засгийн хувьд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжих шилжилтийг хэрэгжүүлж эхэлсэнээр ард иргэдийн дунд өмч хөрөнгөтэй болохын тулд хувийн бизнес эрхлэх шаардлагатай юм байна гэсэн ойлголт бий болсон. Үүний тулд тэд бизнес болон хувийн аж ахуй эрхлэж худалдаа наймааг чөлөөтэй хийх боломж анх удаа бүрдсэн. Ийнхүү нийгэм, эдийн засгийг бүхэлд нь хамарсан өөрчлөлт шинэчлэлтийг эрчимжүүлэхэд тухайн үеийн төр засгаас авч хэрэгжүүлсэн бодлогын шинж чанартай дараах томоохон арга хэмжээнүүд түлхэц болсон гэж үзэж болно. Үүнд:

1. Шилжилтийг амжилттай хийхэд шаардлагатай зах зээлийн харилцааг зохицуулах хууль, эрх зүйн орчинг цоо шинээр бүрдүүлэх,

2. Социализмын бүтээн байгуулалтын үр дүнд бий болсон 100 хувь төрийн мэдэлд байсан төрийн монопольт өмчийг хувьчлах замаар ард иргэддээ хувьцаа болгон үнэ төлбөргүй тэгш хуваарилах үүднээс хувьчлалыг хийх,

3. Төрийн зүгээс тогтоодог байсан бүх төрлийн бараа материал, ажил үйлчилгээний үнэ тарифийг чөлөөлж цаашид зах зээлийн зарчмаар тогтоодог болгох тогтолцоо руу шилжүүлэх,

4. Тухайн үед тус орны гадаад худалдаа зөвхөн ЭЗХТЗ-ийн орнуудын хүрээнд хийгдэж дэлхийн бусад гуравлагч оронтой гадаад худалдаа хийх нь хаалттай байсаныг халж дотоод зах зээлээ нээлттэй болгох үүднээс гадаад худалдааг либералчлах, өөрөөр хэлбэл гадаад худалдааг чөлөөлөх,

5. Тэр үед улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох монгол төгрөг зөвхөн ЗСБНХУ-ын шилжих рубльтай харилцах дансны бичилтийн зарчмаар харьцаж байсаныг эс тооцвол гадаадын ямар ч улсын валюттай харьцдаггүй байсныг өөрчилж төгрөгийн бусад валюттай харьцах ханшийг тогтоох, өөрөөр хэлбэл төгрөгийн ханшийг чөлөөлөх гэх мэт.

Эдгээр хүнд хэцүү арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд тухайн үеийн төр засгийн удирдагч нар ихээхэн хүч хөдөлмөр зарж идэвхи зүтгэл гаргаж Олон улсын эдийн засаг санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, тэднээс санхүүгийн тусламж, техникийн зөвлөгөө авч шилжилтийг маш хурдан хугацаанд хэрэгжүүлж дуусгана гэж зорьж байсан. Энэ нь томоохон алдаа, дутагдлыг дагуулж байсан боловч өнөөгийн хөгжлийн өндөрлөгөөс харахад алдсанаасаа оносон нь илүү байгааг амьдрал харуулж байна. Ийнхүү дээрхи зоригтой бөгөөд тууштай арга хэмжээний үр дүнд манай улсад ард иргэд өөрийн хүсэл санаачлагаар аж ахуй бизнес эрхлэх эрх зүйн болоод эдийн засгийн нөхцөл бүрдэж эхэлсэн гэж хэлж болно.

Дээр дурьдсан өөрчлөлт шинэчлэлийн үр дүнд Монгол Улсын эдийн засагт хувийн өмчийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь жил тутам өсөн нэмэгдэж байгааг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо

	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Бүгд тоо	22724	27271	29142	31478	34218	39677	48879	55901	60535	64574
Хувийн секторын эзлэх хувь	79,9	82,7	83,7	85,0	86,8	88,6	90,5	91,3	92,0	92,5

Эх уусвэр: Үндэсний статистикийн хорооны мэдээлэл 2010 он

Нийт аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэрээр нь авч үзвэл 92,5 хувийг хувийн өмч бүхий аж ахуйн нэгж байгууллага эзэлж байна.

Эндээс харахад асар богино хугацаанд хувийн өмч хөрөнгө тус улсын эдийн засагт өөрийн байр суурийг баттай эзлэж чадсанаар барахгүй энэ нь нийгмийн хурц асуудал болох ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүн амыг ажлын байраар хангах, хүн бүрийг үйлдвэрлэл, бизнес эрхлэж үйлдвэрлэгч болгоход ч түлхэц өгч байна.

**Хүснэгт 2. ДНБ-ний хэмжээ ба нийт ажилчдын тоо
(салбарын бүтцээр) хувиар**

№	Эдийн засгийн үйл ажиллагаа (салбараар)		Үзүүлэлт	2000	2005	2006	2007	2008	2009	
1	Хөдөө аж ахуй		ДНБ	30.7	21.9	19.5	20.5	21.6	21.2	
			Ажилчдын тоо	48.6	39.9	38.8	37.7	40.6	40.0	
2	Аж үйлдвэр		ДНБ	21.3	33.5	40.4	40.1	32.9	32.1	
			Ажилчдын тоо	14.1	16.8	17.3	17.9	15.2	14.9	
	Үүнээс:	Уул уурхай, олборлох үйлдвэр	ДНБ	11.0	22.1	30.0	29.5	22.5	22.5	
			Ажилчдын тоо	2.3	4.1	4.1	4.3	3.0	2.4	
		Боловсруулах үйлдвэр	ДНБ	5.7	5.8	5.5	6.1	6.2	5.9	
			Ажилчдын тоо	6.7	4.7	4.7	4.7	6.5	5.8	
		Барилга	ДНБ	1.9	2.5	2.1	2.2	1.9	1.2	
			Ажилчдын тоо	2.9	5.1	5.6	5.9	3.6	4.7	
	3	Үйлчилгээний салбар		ДНБ	48.1	44.6	40.1	39.4	45.5	46.7
				Ажилчдын тоо	37.2	43.3	43.9	44.5	44.2	45.0
Үүнээс:		Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	ДНБ	13.4	14.9	14.1	13.6	15.0	12.2	
			Ажилчдын тоо	10.4	14.7	15.9	15.8	10.5	12.1	
		Тээвэр агуулахын аж ахуй, холбоо	ДНБ	10.7	12.3	9.9	10.1	10.0	11.2	
			Ажилчдын тоо	4.2	4.4	4.1	4.3	7.3	7.6	
		Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	ДНБ	2.3	3.6	2.9	3.3	3.5	3.0	
			Ажилчдын тоо	0.8	1.7	1.7	1.7	1.4	1.5	
		Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	ДНБ	12.1	7.9	6.8	5.9	8.1	9.1	
			Ажилчдын тоо	0.9	0.9	1.2	1.4	2.1	1.8	

Эх уулавэр: Үндэсний статистикийн хорооны мэдээлэл 2010 он

Хүснэгтээс харахад манай улсын уламжлалт мал аж ахуйн салбар нь 2000 онд ДНБ-ний 30.7 хувийг үйлдвэрлэж, манай улсын нийт ажилчдын 48.6 хувийг мал аж ахуй эрхэлдэг малчин иргэд эзлэж байв.

Харин 2000-2003 онд учирсан байгалийн гамшгаас үүдэн ДНБ болон нийт ажилчдын тоонд хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь буурч, үйлчилгээний салбарын хувийн жин өссөн байна. 2009 онд нийт ажилчдад эзлэх хувийн мал аж ахуй эрхэлдэг малчин иргэдийн тоо 40 хувь хүртэл буурсан байгаа нь байгаль цаг агаарын дулаарлаас

болж экологийн тэнцвэрт байдал алдагдаж зунд нь ган, өвөлд нь зуд ихээхэн нүүрлэснээс хөдөө орон нутагт мал аж ахуй эрхлэх боломж нөхцөл улам багасаж байна. Үүнтэй холбоотой ажилгүйдэл ихээхэн нэмэгдэж малчин иргэд нүүдлийн мал аж ахуйгаасаа татгалзаж хот руу ихээхэн нүүж ирж суурьшиж байна. Гэсэн хэдий ч бусад салбартай харьцуулахад мал аж ахуйн салбар нь хамгийн өндөр хувийг эзэлсээр байна. Эндээс дүгнэлт хийхэд Монгол Улсын аж ахуй, бизнес эрхлэлтийн онцлог нь мал аж ахуй болон түүнээс гарах малын түүхий эд, ашиг шимийг худалдаалах үйл ажиллагаан дээр тулгуурладаг онцлогтой болох нь харагдаж байна.

Харин сүүлийн хоёр жилд ДНБ-д аж үйлдвэрийн салбар 22.5 хувийг эзлэж, түүнд ажиллаж байгаа ажилчдын тоо 14-17 хувийн хооронд хэлбэлзэж байгаа нь тийм ч бага үзүүлэлт биш боловч улс оронд нүүрлээд байгаа ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн зарим эмзэг асуудлыг шийдвэрлэх хэмжээнд хүрч чадахгүй байгаа нь чамлалтай байна.

Аж үйлдвэрийн салбар дотор уул уурхайн салбарын үйлдвэрлэл мэдэгдэхүйц өсч 2007 онд ДНБ-ний 29.5 хувийг эзлэж, тэнд ажиллах ажилчдын тоог нэмэгдүүлж байсан боловч 2008 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас болж энэ салбар руу орох гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ багасаж тэнд ажиллаж байсан ажилчдын тоо буурсаныг харж болно.

Гэвч сүүлийн 2 жилд манай улсын уул уурхайн салбар руу гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж энэ салбарт эрс сэргэх болсон нь ашигт малтмалын шинэ шинэ орд газруудыг илрүүлэн нээсэнтэй холбон тайлбарлаж болно. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн хөгжилд түлхэц өгсөн дараах хүчин зүйлийг нэрлэж болно. Үүнд:

1. Манай улсын Өмнөговь аймгийн нутагт байршилтай зэсийн 0,7 хувь, алтны 0,28 г/т, молибдений 62,21 г/т, мөнгөний 1,87 г/т агуулгатай, 6451,5 сая тонн хүдэрт зэс 45,032 сая тонн, алт 1838 тонны геологийн дундаж нөөцтэй болох нь батлагдсан “Оюу-толгой” орд газрыг Канадын “Ivanhoe mines inc” компанитай хамтран ашиглах гэрээг байгуулсан явдал,

2. Мөн тус аймгийн нутагт байршилтай дэлхийд томоохонд тооцогдох 6.5 сая тонн нүүрсний нөөцтэй ордноос 4.5 сая тонны коксжих нүүрсний нөөцтэй болох нь батлагдсан “Таван-толгойн” орд газрыг гадаадын хөрөнгө оруулагчдтай хамтарч эзэмших шийдвэрийг УИХ-аас гаргасан зэрэг нь дэлхийн нэр хүнд бүхий хамгийн том компаниуд энэ орд газар руу хөрөнгө оруулахад бэлэн байгаа саналаа илэрхийлэх болж Монгол Улс дэлхийн уул уурхайн томоохон хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд зүй ёсоор орж байна.

Эдийн засагт хамгийн өндөр хувийг эзэлж ирсэн үйлчилгээний салбар 2009 онд ДНБ-ний 46.7 хувь болж, энэхүү салбарт ажилчдын

тоо 45 хувь хүртэл өссөн байна. Энэ салбарт хамгийн өндөр хувийг бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ эзлэж энэ чиглэлээр жижиг бизнесийн эрхлэгчдийн тоо 15.8 хувьд хүрсэн байгаа нь манай улсын эдийн засаг үндсэндээ үйлчилгээн дээр тогтож байгаа мэт дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 3. Нийт бүртгэлтэй жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн тоо (салбараар)

Салбар		2006		2007		2008		2009	
		Нийт тоо	хувь	Нийт тоо	хувь	Нийт тоо	хувь	Нийт тоо	хувь
Нийт аж ахуйн нэгжийн тоо		48879	100.0	55901	100.0	60535	100.0	64574	100.0
Жижиг дунд үйлдвэрийн тоо		36751	75.1	42254	75.5	46421	76.6	50266	77.8
Үүнээс:	Бөөний худалдаа	10896	29.6	13419	31.7	16758	36.1	18287	36.3
	Жижиглэнгийн худалдаа	8793	23.9	9576	22.6	9411	20.2	10036	19.9
	Үйлчилгээ	17062	46.4	19259	45.5	20252	43.6	21943	43.6

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны мэдээлэл 2010 он

Хүснэгтээс харахад хэдийгээр 2008-2009 онд дэлхийн санхүү, эдийн засгийн хямралтай байсан ч манай улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт аж ахуй нэгжийн тоо буураагүй харин ч өссөн тоо гарч байна.

2009 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар гаргасан статистикийн мэдээнээс үзвэл улсын хэмжээнд албан ёсны бүртгэлтэй 64574 аж ахуйн нэгжээс 36426 нь буюу 56.4 хувь нь байнгын үйл ажиллагаагаа явуулж байна. Үлдэх 43.5 хувь нь тухайн компаний удирдлагын менежментийн мэдлэг ур чадвар сул, эхлэлтийн бөгөөд эргэлтийн хөрөнгөө бүрдүүлэхэд зээлийн хүү өндөр, хугацаа богино, зээлийн нөхцөл хатуу, зээлийн барьцаанд тавих өмч хөрөнгөгүй, тоног төхөөрөмж хуучирч элэгдсэн, үйлдвэрлэсэн бага хэмжээний бүтээгдэхүүн нь борлуулалт байхгүй, түүнийг гадны ижил төрлийн бараатай өрсөлдөхөд эрх зүйн хамгаалалт байхгүй зэргээс болж үйл ажиллагаагаа явуулахгүй байна гэж тайлбарлаж болно.

Гэсэн хэдий ч нийт аж ахуй нэгжид эзлэх жижиг дунд үйлдвэрийн тоо өсөж 2009 оны эцэст 77.8 хувьд хүрсэн нь иргэд хувийн аж ахуй бизнес эрхлэх хүсэл сонирхол хараахан буураагүй харин ч улам нэмэгдэж байгааг харуулж байна. Жижиг дунд үйлдвэрийг салбараар авч үзвэл түүн дотор хамгийн өндөр буюу 43.6 хувийг бүх төрлийн үйлчилгээ, 36.3 хувийг бөөний болон агуулахын худалдаа, 19.9 хувийг жижиглэнгийн худалдаа эзлэж байна. Энэ байдлыг дүгнэж хэлэхэд

манай улсын жижиг дунд аж ахуйн нэгжүүд материаллаг үйлдвэрлэл эрхлэж нэмүү өртөг үйлдвэрлэхээсээ илүү бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэж, бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх замаар маш богино хугацаанд эргэлттэй, хөрөнгө, хүчин чармайлт бага шаардсан эрсдэл багатай бизнес эрхлэх сонирхолтой болсоныг харуулж байна.

Хүснэгт 4. Монгол Улсад бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалтай компаний тоо (салбараар)

№	Салбарын нэр	Нийт		1990-2004	2005	2006	2007	2008	2009	2010.6.30
		%	тоо							
1	Худалдаа, нийтийн хоол	63.4	6515	969	522	1112	1505	1515	572	320
2	Бусад	14.3	1469	860	297	262	21	3	15	11
3	Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл	3.8	386	327	15	14	20	4	6	
4	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт	3.5	365	272	27	22	23	4	12	5
5	Аялал жуулчлал	3.0	304	176	57	35	23	12	1	
6	Хөнгөн үйлдвэр	1.8	190	167	7	14	1	1		
7	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1.7	179	172	5	2				
8	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт	1.5	158	149	4	4				1
9	Тээвэр	1.1	117	101	7	3	1	1	2	2
10	Мэдээлэл, холбооны технологи	1.0	106	72	7	11	7	6	2	1
11	ХАА, газар тариалан, МАА	1.0	102	86	8	5	1		1	1
12	Мебель, модон эдлэл	0.7	77	71	2	4				
13	Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	0.6	64	60	1	3				
14	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	0.5	56	36	2	5	7	4	2	
15	Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ	0.5	52	47	1	2		1		1
16	Эрчим хүч	0.4	44	39	4	1				
17	Нийтийн ахуйн үйлчилгээ	0.4	40	36	2	2				
18	Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл	0.3	29	23	3	3				
19	Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл	0.2	21	21						
20	Үнэт зүйлс, бэлгэ дурсгал	0.1	8	7		1				
	Нийт ГХОКомпаний тоо	100	10282	3691	971	1505	1609	1551	613	342

Эх уусвар: Гадаадын хөрөнгө оруулалтын газрын 2010 оны эхний хагас жилийн статистикийн мэдээ

Хүснэгтээс харахад манай улсын эдийн засагт хөрөнгө оруулсан гадаадын компаниудын 63.4 хувь нь худалдаа, нийтийн хоолны салбарт, 3.8 хувь нь инженерийн барилга байгууламж, барилгын материалын

үйлдвэрлэлд, 3.5 хувь нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолтын салбарт хамгийн их хөрөнгө оруулж үйл ажиллагаа явуулж байхад мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл, гэр ахуйн модон болон төмөр хэрэгслийн үйлдвэрлэл, үнэт зүйлс, бэлэг дурсгалын зүйлсийн үйлдвэрлэл эрхэлдэг компанид хамгийн бага гадаадын хөрөнгө ордог байна. Өөрөөр хэлбэл гадаадын хөрөнгө оруулагчид манай улсын эдийн засгийн хамгийн хурдан ашгаа олж авах боломжтой салбаруудад хөрөнгө оруулж энэ нь эдгээр салбаруудын хувьд гадны шударга бус өрсөлдөөнтэй тулгардаг болох нь харагдаж байна. Энэ байдал нь Монгол Улсад жижиг дунд үйлдвэрлэл шинээр үүсэж хөгжихөд ихээхэн саад бэрхшээлийг дагуулж байгаа нь дамжиггүй юм. Эдгээр салбарыг гадны өрсөлдөөнөөс хамгаалах, тэдний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн эд зүйлсийг борлуулах гадаад болон дотоод зах зээл дээр ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд төрийн зүгээс бодлогоор хамгаалалтын болон санхүүгийн, зохион байгуулалтын хувьд дэмжлэгийн зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ялангуяа алслагдсан аймаг, суманд жижиг дунд үйлдвэрлэлийг эрхлэхэд шаардлагатай юуны өмнө бүх сум сууринг гэрэл, цахилгаантай болгох, зам, тээвэр, харилцаа холбоог хөгжүүлж, үйлдвэрлэгчдийг сургалт, дадлагад хамруулах, тэднийг сүүлийн үеийн шинэ дэвшилтэт техник, технологийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслээр хангах нь чухал байна. Ингэснээр хөдөө орон нутагт мал аж ахуйн түүхий эдийн боловсруулах жижиг үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжиж шинээр ажлын байр бий болгох, малчдын орлогыг нэмэгдүүлэх замаар амьжиргааг дээшлүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулахад чухал ач холбогдолтой болно гэж дүгнэж байна.

Ашигласан материал:

1. Монгол Улсын “Жижиг дунд үйлдвэрийн тухай” 2007 оны 07 сарын 27-ний өдөр батлагдсан хууль.
2. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Жижиг дунд үйлдвэрийн газрын тайлан. 2009 он.
3. Монгол Улсын Хүнс хөдөө, аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны тайлан., 2009 он.
4. Монгол Улсын Гадаадын хэргийн яамны гадаад хөрөнгө оруулалтын газрын 2010 оны эхний хагас жилийн тайлан.,
5. Хөдөлмөр Халамж үйлчилгээний газрын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос хийсэн “Цалин хөлсний бүтцийн туршилтын судалгааны” тайлан., 2010 он.
6. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос Монголыг Бүтээмжийн төвтэй хамтран хийсэн “Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн харьцаа, хандлага” сэдэвчилсэн судалгааны тайлан, 2010 он.

Цахим мэдээлэл:

1. www.oyutolgoi.mn
2. <http://www.investmongolia.com>
3. <http://www.nso.mn/>
4. <http://www.legalinfo.mn/>
5. <http://www.egov.mn/>
6. www.mfat.gov.mn/
7. <http://www.ecustoms.mn/>
8. <http://www.open-goverment.mn>